


УЛААН БАТЛАВ.  
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ  
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ *Джам* Б.НЯМСАМБУУ



110/10 кВ-ын “Баруун” дэд станцын нум унтраах 10 кВ-ын I, II-р секцэнд автомат удирдлагатай реактор, фильтрууд, хуурай салгуур шинээр суурилуулж РХА-ийн холболт, 10 кВ-ын гарсан шугамуудын тэг дарааллын гүйдлийн трансформаторуудыг шинэчлэхэд олгох техникийн нөхцөл

Дугаар...*06/2020*.....

*2020* оны *02* сарын *02* өдөр


Улаанбаатар хот

1. **Техникийн нөхцөл хүссэн хэрэглэгчийн нэр:** “ЦДҮС” ТӨХК
2. **Хэрэглэгчийн хаяг:** УБ хот, Хан-Уул Дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 17033.
3. **Ажил үйлчилгээний зориулалт:** Автомат удирдлагатай реактор, фильтрууд, хуурай салгуур шинээр суурилуулж РХА-ийн холболт, 10 кВ-ын гарсан шугамуудын тэг дарааллын гүйдлийн трансформаторуудыг шинэчлэх
4. **Техникийн нөхцөл олгох үндэслэл:** Компанийн 2020 оны техник зохион байгуулалтын ажлын хүрээнд
5. **Холбогдох цэг:** 110/10 кВ-ын “Баруун” дэд станцын 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж
6. **Тусгай заалтууд:**
  - 110/10 кВ-ын “Баруун” дэд станцын нэг фазын газардлагын гүйдэл ба нуман газардлагын үед бий болох хэт хүчдэлийг бууруулах зорилгоор автомат удирдлагын систем бүхий, гэмтэлтэй фидерийг сонгож таслах тохируулгатай реакторын байгууламжийг дэд станцын ил хуваарилах байгууламж ба 10 кВ хаалттай хуваарилах байгууламжид байрлуулах бөгөөд байршлыг зураг төслийн тооцоогоор сонгох,
  - 110/10 кВ-ын “Баруун” дэд станцын 10 кВ-ын I ба II секцэд суурилагдах автомат удирдлагын систем бүхий тохируулгатай реактор нь Олон улсын стандарт шаардлагыг хангасан байх
  - Шинээр суурилуулах реактор, удирдлагын систем ба резистор, РХА-ын холболт, газардуулах байгууламж, туслах тоноглолын зураг, техникийн өгөгдөл зэргийг 10 кВ-ын өргөтгөл болон холболтын зураг төслийг боловсруулах болон барилга угсралтын шатанд албан тоотоор ЦДҮС ТӨХК-д ирүүлж танилцуулан зөвшөөрөл авсан байх.
  - Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөж, магадлалын ерөнхий дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.

- 110/10 кВ-ын “Баруун” дэд станцад суурилагдах тоноглол Монгол улсын цаг уурын нөхцлийг хангасан /-45°C-ээс +45°C/ ,далайн түвшний өндөршил 1350 м-ээс дээш , IEC стандартыг хангасан байх
- Шинээр суурилуулж буй тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх , ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд тэсвэртэй байх
- Тоноглолын ашиглалтын зааврыг Монгол хэл дээр боловсруулж хүлээлгэн өгөх
- Дэд станцад 10 кВ-ын хуурай салгуур шинээр суурилуулж РХА-ийн холболт хийх
- 10 кВ-ын гарсан шугамуудад шинээр тэг дарааллын гүйдлийн трансформатор суурилуулж, газардлагын хамгаалалтыг оруулах,
- Цахилгаан тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралт, туршилт, тохируулгын ажлыг “Техник ашиглалтын дүрэм” ,”Цахилгаан төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааны дүрэм ” –ийн дагуу эрчим хүчний зураг төсөл , эрчим хүчний барилга угсралт хийх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх
- Шинээр суурилагдах тоноглолууд нь дэд станцын аянга хамгаалалтын бүсэд багтах эсэхийг зураг төслийн шатанд тооцоогоор шийдвэрлэх
- Шинээр суурилагдах тоног төхөөрөмжүүдийн техникийн бичиг баримтууд, (тухайлбал: техникийн паспорт, ашиглалтын заавар, зураг, схем г.м)-ын иж бүрдүүлэлтийг бүрэн хангасан байх
- Газардуулах байгууламжийг норм дүрмийн дагуу хийх ба ТАД-ийн 5.4.10 заалтын дагуу шинээр суурилуулах тоноглолын байнгын газардуулгыг дэд станцын газардуулгын системд холбох
- Энэхүү техникийн нөхцөл олгогдсон өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй

Техникийн нөхцөл олгох комиссын гишүүд:

Комиссын дарга:



Б.Дашдаваа / Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер /


Комиссын гишүүд:



Д.Чинбат / Техникийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /




М.Өмербай / Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга /



Н.Батбаяр / Реле хамгаалалт, туршилт хэмжүүрийн хэлтсийн дарга /

Д.Жаавай / Улаанбаатар салбарын ерөнхий инженер /

Боловсруулсан:



Б.Пүрэвхүү / Техникийн нөхцөл хариуцсан инженер /